ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555
И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.09.04 № 01/1268

танай ____________-ны № ____________-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭДҮҮДЭД

"Эрдэнэс Тавантолгой" ХК-аас зарласан ЭТТХК/20240102100 дугаартай "Тавантолгой ордыг цогц, иж бүрнээр ашиглах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах үйлчилгээ" үзүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

Хавсралт: 2 хуудас.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Х.МӨНХЖАРГАЛ

1124050809

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ

ЭТТ

Тодруулгын хариу

| | |
|---|---|
| Тендерийн нэр | Тавантолгой ордыг цогц, иж бүрнээр ашиглах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах |
| Тендерийн дугаар | ЭТТХК/20240102100 |
| Тендер зарласан огноо | 2024 оны 06 дугаар сарын 12 |
| Тендер нээх огноо | 2024 оны 07 дугаар сарын 18 |

**Тодруулга №1**

| Тодруулга | Хариу |
|---|---|
| "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 16.6, 17.5-р заалтуудын дагуу тендерийн баримт бичгүүдэд тодорхой тусгагдаагүй байгаа тул Санхүүгийн болон техникийн шаардлагуудыг үндсэн компани, түншлэгч компани нар тус бүр 100% хангасан байх уу, эсхүл нийлбэр дүнгээрээ хангасан байх уу. Тодруулбал:<br><br>1. ТШЗ 19.1-д заасан үндсэн ажилтнуудын зарим нь Түншлэгч компанийн үндсэн ажилтан байж болох эсэх.<br>2. ТШЗ 19.1-ийн 5-д заасан "Сүүлийн 3-н жил батлагдсан төсөвт өртгийн 30%-иас багагүй ТЭЗҮ боловсруулж батлуулсан байна" гэсэн шаардлагыг Үндсэн компани болон Түншлэгч компани нар хоёул хангаж байх шаардлагатай юу. Эсвэл нийлбэр дүнгээрээ хангасан байх уу. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дах заалт Түншлэлийн гишүүн тус бүрийн болон хамтдаа хангавал зохих санхүүгийн чадавхын доод шаардлагыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана. Мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дах заалт Түншлэлийн гишүүн тус бүрийн болон хамтдаа хангавал зохих техникийн чадавх, туршлагын доод шаардлагыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана гэж заасны дагуу ТШЗ 19.1-д заасанаар тус бүр хангасан байна. Тухайлбал: Тендер шалгаруулалтын зааварчилгааны:<br>7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага,<br>13. Тендерийн иж бүрдэл,<br>16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг,<br>17. Чадавхын болон туршлагын шаардлага.<br>19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт,<br>24. Тендерийн баталгааг ирүүлж дээрх шаардлагыг бүрэн хангасан байна. |

**Тодруулга №2**

| Тодруулга | Хариу |
|---|---|
| "Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын нийлбэр нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй орд ашиглах ТЭЗҮ боловсруулж, батлуулж | ТШЗ 19.1-д зааснаар Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын нийлбэр нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас |

| | |
|---|---|
| байсан туршлагатай байна" гэсэн шаардлагад 2020 онд байгуулсан гэрээтэй, 2022 онд ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн дүгнэлт, тушаалтай ТЭЗҮ тооцогдох эсэх. | багагүй үнийн дүнтэй орд ашиглах ТЭЗҮ боловсруулж, батлуулж байсан туршлагатай байхыг шаардана. |
| **Тодруулга №3** | |
| **Тодруулга** | **Хариу** |
| Зөвлөх инженерийн багийн мэргэжилтнүүд нь стратегийн орд газруудын ТЭЗҮ-д Зөвлөхөөс гадна Шинжээчээр ажиллаж байсан бол тус туршлагыг ажлын туршлагад оруулан тооцох уу. | ТШЗ 19.1-д зааснаар үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг хангасан байна. |
| **Тодруулга №4** | |
| **Тодруулга** | **Хариу** |
| ТШЗ 19.1-д заасан мэргэжилтнүүдээс Зөвлөх инженерийн баг, Инженерийн багийн Цахилгааны инженерүүд нь "Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт"-ын мэргэжилтэй байж болох эсэх. | ТШЗ 19.1-д заасан мэргэжилтэн байна. |
| **Тодруулга №5** | |
| **Тодруулга** | **Хариу** |
| ТЭЗҮ-ийн Шинжээчдийн төлбөрийг аль тал хариуцах вэ? Шинжээчдийн зардлыг ТЭЗҮ боловсруулах үнийн санал тооцож оруулах уу. | Шинжээчдийн зардлыг ТЭЗҮ боловсруулах үнийн санал оруулан тооцохгүй. |